



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХОРИН
ДӨРӨВДҮГЭЭР ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 02

Чингис хот

Хэнтий аймгийн 2021-2025 оны таван
жилийн үндсэн чиглэлийн 2023 оны
тайланг дүгнэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хорин дөрөвдүгээр Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2023 оны хэрэгжилтийг “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсүгэй.

2. Үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтийн үр дүнг 2025 оны 01 дүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Чогсомжав)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хөгжлийн хороо (Ц.Чинзориг)-нд даалгасугай.

ДАРГА

Г.ХЭРЛЭНЧУЛУУН



Аймаг, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө
Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар
2023 оны жилийн эцэс

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Хүрсэн түвшин, үр дүн	Хувь
1. 1. Хүний хөгжил							
1	1.1.1.. МУХТЖҮЧ 2.2.1, ЗГҮАХ 2.1.1, ХАХТЖҮЧ 2.2.3, АЗДҮАХ-ийн 2.1.9	1.1.1.1.. Яаралтай тусламжийн бэлэн байдал, багаж, техник, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх.	49%	Хангалтын хувь	52%	2023 онд 489.4 сая төгрөгийн 24 төрлийн тоног төхөөрөмжөөр 12 эрүүл мэндийн байгууллагыг хангасан. Үүнд: УТХОруулалтаар яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах зорилгоор /зөөврийн ЭХО, Биохимийн анализатор, өвчтөний ор иж бүрдэл, суурин компьютер г.м/ 233.3 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмжүүдийг аймгийн Нэгдсэн Эмнэлэг, Дадал, Жаргалтхаан, Бор-Өндөр, Баянхутаг, Норовлин сумдын эрүүл мэндийн төвүүдэд олгосон. ОНХО-р нэгдсэн эмнэлэг, Цэгцүүлэн дом ӨЭМТөв, Норовлин, Бэрх, Мөрөн, ЗӨСТөвд 145.5 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмжийг олгосон. Мөн ДЭМБайгууллага, НҮБ-ын дэмжлэгээр 71.1 сая төгрөгийн ариутгалын багаж хэрэгсэл, орон нутаг дахь шуурхай удирдлагын нэгжид шаардлагатай 7 нэр төрлийн 39.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус олгосон. Яаралтай тусламжийн багаж тоног төхөөрөмжийн хангалт 53.1% байна.	100%
2		1.1.1.2.. Нийт хүн амын 65%-ийг зорилтот бүлгийн 70%-ийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулна.	55%	зорилтот бүлгийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээн д хамрагдалтын хувь	60%	Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор жил бүр 20 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр сумдад нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг жил бүр бүсчлэн зохион байгуулж хэвшсэн. Уг үзлэг, шинжилгээ, оношилгоог Нэгдсэн эмнэлэг болон бусад төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч /дотор, мэдрэл, хүүхэд, эмэгтэйчүүд, сүрьеэ, БЗДХ, гэмтэл, урологи/ нартай хамтран зохион байгуулдаг бөгөөд өссөн дүнгээр 4 бүсийн 18 сум, 5 тосгоны нийт 21275 иргэнийг хамруулсан. Мөн зонхилон тохиолдох халдварт бус өвчний анхдагч хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр хүн амын дунд 12 төрлийн олон нийтийн арга хэмжээ, 13 төрлийн эрүүл мэндийн тэмдэглэлт	100%

						өдрүүдийг бусад эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж 32600 гаруй иргэдийг хамруулсан нь зорилтот бүлгийн хүн амын 64.4%-ийг эзэлж байна.	
3		1.2.1.1.. Аймгийн бүх сургууль, цэцэрлэг, политехник коллежуудаас жил бүр гарааны үнэлгээ тогтоож, чанарын шалгалт авна.	ЕБС-ийн чанар 47.1, СӨБ-ын сургалтын чанар 83.3%-тай байна.	Сургалтын чанарын хувиар	ЕБС, СӨБ, политехник коллежийн сургалтын чанарыг 1.5 хувиар ахиулна.	СӨБ-ын үнэлгээ 89.14 болж суурь түвшингээс 10.8 хувиар ахисан бол ЕБС-ийн сургалтын чанар 52.75 буюу суурь түвшингээс 18.5 хувиар ахисан байна.	100%
4	1.2.1. МУХТЖҮЧ 2.1, ЗГҮАХ 2.3.8, АЗДҮАХ-ийн 2.3.2	1.2.1.2.. Мэргэжлийн зэрэг ахиулах мэргэшүүлэх, түргэвчилсэн, хөрвөх сургалтыг орон нутагт зохион байгуулж, мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлнэ.	Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий сургуулийн багш нарын хангалт 97%-тай байна.	багш нарын хангалтын хувиар	Мэргэжлийн боловсон хүчний хангалт 1 хувиар нэмэгдсэн байна.	2023 оны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг цахим болон танхимаар 8 удаа зохион байгуулж нийт 288 багш хамрагдан, мэргэжлийн зэрэгтэй багш 477 байснаас 492 болж 3.1хувиар өссөн бол СӨБ-ын үндсэн багш 98.3%, ЕБС-ийн багшийн хангалт 98.3%- тай бол өмнөх оноос 1.3%-иар өссөн дүнтэй байна. ЕБС-ийн хүний нөөцийг бүрдүүлэхийн тулд 16 сургуульд 36 ахмад багшийг үндсэн болон гэрээгээр ажиллуулж мөн дадлагажигч багш 3 ажиллаж байна.	100%
5		1.2.1.3.. Сургууль цэцэрлэгийн багш нарын ажлын үр дүнг гүйцэтгэлд тулгуурлан тооцно.	Математик сургалт 9 болон 12 ангийн сургалтын чанар 34.6% байгалийн ухааны сургалтын чанар 36.4%-тай байна.	9 болон 12 ангийн сургалтын чанарын хувиар	Математик сургалт 9 болон 12 ангийн сургалтын чанар 35.5% байгалийн ухааны сургалтын чанар 37.5%-д хүрсэн байна.	2023 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн үнэлгээгээр 9 болон 12 ангийн математикийн сургалтын чанар 41,1 болж 5,6 өссөн, 9 болон 12 ангийн Байгалийн ухааны сургалтын чанар 37,8 болж 0,3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.	100%
6	1.3.1.. МУХТЖҮЧ 2.6.2, ЗГҮАХ 2.5.14, ХАХТЖҮЧ 2.5.1, АЗДҮАХ-ийн 2.4.4	1.3.1.1.. Улсын болон орон нутгийн төсвийн бүтээн байгуулалтын хүрээнд жил бүр шинээр 120-оос доошгүй иргэнийг ажлын байраар хангасан байна.	Аймгийн хэмжээнд 250 шинэ ажлын байр бий болсон. Үүнээс 72 нь бүтээн байгуулалтын ажлын хүрээнд бий болсон ажлын байр байна.	Ажлын байраар хангагдсан иргэний тоогоор	120-оос доошгүй иргэнийг ажлын байраар хангасан байна.	Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн хүрээнд 2023 онд Говь ХХК 58, хөдөө аж ахуйн цогцолбор парк төслийг хэрэгжүүлж байгаа М-Агро компани 60, Үүрэн холбооны Жимобайл компани 15, Ерөнхий боловсролын 5-р сургууль 53, Барилгын салбарт 109, уул уурхайн салбарт 135 нийт 430 иргэнийг байнгын ажлын байраар ханган тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлж, орон нутгийн иргэдийн өрхийн орлого нэмэгдсэн.	100%
7	1.3.2.. МУХТЖҮЧ 2.5, ХАХТЖҮЧ 2.3.1, АЗДҮАХ-ийн 2.4.9	1.3.2.1.. Хүүхдэд ээлтэй орон нутгийн 6 шалгуур үзүүлэлтийг	6,3 нэгж	Хүүхдэд ээлтэй байдлын индексээр	Хүүхдэд ээлтэй байдлын индекс 7 нэгж болсон байна.	Хүүхдэд ээлтэй байдлын индексийг нэг нэгжээр ахиулах ажлын хүрээнд 2023 оныг Хүүхдийн хөгжил хамгааллын жил болгон зарлаж, 105 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулан	90%

		н хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжиж, эрсдэлд нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх.			хүүхдийг эрхийг хангах урьдчилан сэргийлэх болон сургалт нөлөөллийн 31 арга хэмжээ төлөвлөн 90-ээс дээш хувьтай хэрэгжүүлсэн. Хүүхдийн хөгжил, хамгааллын жил болгон зарласны үр дүнд өмнөх оны мөн үеэс насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэг 35,7 хувиар буурсан, насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн гэмт хэрэг 40,5 хувь буурсан, насанд хүрээгүй сэжигтэн 45,8 хувь буурсан, насанд хүрээгүй хохирогч 28,6 хувь буурсан, түр хамгаалах байраар үйлчлүүлсэн хохирогчийн тоо 74,6 хувиар буурсан үр дүнтэй байна. Мөн урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажил, жүжиг, контент, цуврал лекцийн арга хэмжээ, сэтгэл зүйн явуулын үйлчилгээнд хамрагдсан хүний тоо 27,8 хувиар нэмэгдэж хувь хүний хандлага, сэтгэл зүйн байдал, зан төлөвт эерэг байдлаар нөлөөлсөн. Энэ онд аймгийн хэмжээнд 16 сургуулийн дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулсан. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 34,3 хувиар нэмэгдсэн. Болзошгүй эрсдэлийн даатгалд 256 хүүхдийг хамруулсан нь мөн үеэс 60 хувиар нэмэгдсэн. Хүүхдийн оролцооны байгууллага, клубт хамрагдах хүүхдийн тоо 26 хувиар өссөн үр дүнтэй байна. 2023 оны статистикийн дүн мэдээ нэгтгэгдэж 2024 оны 02 дугаар улиралд 2023 оны индексийг тооцно.		
8	1.3.3.. МУХТЖҮЧ 2.3.1, ХАХТЖҮЧ 2.7.7, АЗДҮАХ-ийн 2.4.10	1.3.3.1.. Жендерийн чиглэлээр орон нутагт тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод цогц үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	-	санхүүгийн дэмжлэг үзүүлсэн эсэх	Санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.	Жендерийн тэгш байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн 14 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулсан. Гэр бүлд боловсрол олгох, Сэтгэл зүйн боловсрол олгох модуль сургалтуудыг 18 сум 1 тосгонд 230 удаа зохион байгуулж нийт 28807 иргэн буюу нийт иргэдийн 36.2%-ийг хамруулсан. Гэр бүлийн цогц сэтгэл зүйн үйлчилгээг анх удаа зохион байгуулж, гэр бүлийн хямралтай, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгддэг 50 өрхийг сонгож сэтгэл зүйн боловсрол олгох, хосын хямралын үеийг амжилттай даван туулах, эцэг, эх, хүүхдийн харилцаанд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, гэр бүлийн харилцааны хямралтай, салах эрсдэлтэй хосууд эвлэрэх , цаашид шаардлагатай сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдах зэрэг үр дүн гарсан. Нэг цэгийн үйлчилгээний төвд 2 ажилтны орон тоог нэмж,	100%

						24 цагийн харуул хамгаалалт, тоног төхөөрөмжийн зардалд нийт 20 сая төгрөгийн төсөв шийдвэрлүүлсэн.	
9	1.3.4.. МУХТЖҮЧ 2.5, ЗГҮАХ 2.5.13, ХАХТЖҮЧ 2.3.2, АЗДҮАХ-ийн 2.4.7.	1.3.4.1.. Тусгай хэрэгцээ шаардлагатай иргэдийн орчны хүртээмжийг сайжруулж, орчин бүрдүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлнэ.	-	аж ахуйн нэгжийн тоогоор	25-аас доошгүй төрийн болон ААНБ-уудад үнэлгээ хийж хүртээмжийг сайжруулна.	Тусгай хэрэгцээ шаардлагатай иргэдийн орчны хүртээмжийг сайжруулах зорилгоор 2023 онд 18 сум, 3 тосгоны Засаг даргын Тамгын газрын байрууд болон Худалдааны төв супермаркет нийт 26 байгууллагад хүртээмжийн үнэлгээг хийж, үнэлгээний дагуу засаж сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр зөвлөмж хүргүүлж, хүртээмжтэй орчныг нэмэгдүүлэн ажилласан.	100%
10	1.4.1.. МУХТЖҮЧ 1.1.5, ХАХТЖҮЧ 1.4.1, АЗДҮАХ-ийн 2.5.1.	1.4.1.1.. Сэцэн ханы ордон музейг хуучны загварт оруулж, сэргээн засварлана.	-	шинээр дэглэгдсэн үзмэрийн тоогоор	Музей засварт орж үзмэр шинээр дэглэгдсэн байна.	Монголын Урлагийн Зөвлөл, М-Си-Эс групптэй хамтран хэрэгжүүлдэг "Өв-Эрдэнэ" төслийн хүрээнд 550 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, АЗДТГ-ын 200 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтээр Сэцэн Ханы Ордон музейн нийт 8225 м2 гадна талбайд тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд явган хүний зам, иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх 5200м2 нийтийн талбайг байгалийн чулуу, хөх тоосго, хөнгөн блокоор тохижуулж, 3000м2 талбайд зүлэгжүүлэлт, ногоон байгууламж, орчны гэрэлтүүлгийн ажлууд хийгдсэн. Мөн Сэцэн ханы ордон музейн танхимуудад байрлаж байсан үзмэрүүдийг шинээр ашиглалтад орсон музейн Угсаатны зүйн танхим, Дүрслэх урлагийн танхим, Сэцэн ханы танхим зэрэг тусгай сэдвийн хүрээнд дэглэн иргэдэд үйлчилж байна.	90%
11	1.4.2.. МУХТЖҮЧ 1.2.1, ХАХТЖҮЧ 1.4.1, АЗДҮАХ-ийн 2.5.3.	1.4.2.1.. Баян-Адарга суманд Дуурлиг нарсны дурсгалт газрын мэдээллийн төв" байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	-	зураг төсөв хийгдсэн эсэх	Мэдээллийн төвийн зураг төсөв хийгдсэн байна.	ШУА-ийн Археологийн хүрээлэн болон музейн албан хаагчдын бүрэлдэхүүн Баян-Адрага суманд ажиллаж "Дуурлиг нарсны дурсгалт газрын мэдээллийн төв"-ийг байгуулах 2га газрын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, гэрчилгээ аван зургийн даалгаврыг аймгийн ГХБХБГ-аар гүйцэтгүүлсэн ба зураг төсөвт 30 сая төгрөг тавьж 2023 онд тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй 2024 онд дахин зарлахаар болсон.	50%
12	1.4.3.. МУХТЖҮЧ 1.1.2, ХАХТЖҮЧ 1.4.1, АЗДҮАХ-ийн 2.5.3.	1.4.3.1.. Аймгийн 100 жилийн ойн арга хэмээний бэлтгэл ажлын хүрээнд "Чингис хаан дуулалт	-	дэмжлэг үзүүлсэн эсэх	"Чингис хаан дуулалт жүжиг" бүтээлийг туурвихад дэмжлэг үзүүлсэн байна.	Чингис хаан дуулалт жүжгийн зохиолын судалгаа дуусч Дуурь бүжгийн эрдмийн театрын ерөнхий найруулагч ирж дуучид болон дүр сонголтыг шалгаруулан бэлтгэлийг хангаж хөгжмийн найруулга хийгдэж, жүжигт шаардлагатай 5бш хувцас, тайз, гол дүрийн бш	100%

		жүжиг" бүтээлийг туурвихад дэмжлэг үзүүлж, олны хүртээл болгоно.				хувцасны захиалга өгөгдсөн. Энэхүү бэлтгэл ажилд зориулж аймгийн ЗДТГ-аас 42 сая төгрөг, Соёлын яамнаас 25 сая төгрөг, нийт 67 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Ирэх 2024 онд олны хүртээл болгож тайзнаа тоглохоор бэлтгэл ханган ажиллаж байна.	
13	1.4.4.. МУХТЖҮЧ 1.1.2, ХАХТЖҮЧ 1.4.1, АЗДҮАХ-ийн 2.5.4.	1.4.4.1.. Аймгийн 100 жилийн ойн хүрээнд "Халхын Сэцэн хаадын ном", баримтат кино гаргана.	-	хэрэгжилтийн хувь	100% хэрэгжсэн байна.	Хан Хэнтий уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан эрхлэн гаргасан "Хан Хэнтий уулын аймаг 100 жил" номонд "Халхын Сэцэнхан аймаг" дэд сэдвээр 16 гарчиг бүхий судалгааны мэдээллийг бэлтгэн хэвлүүлсэн. Мөн Хан Хэнтий нутгаас төрөн гарсан зохиолч, яруу найрагчдын судалгаа хийж 220 хүнийг бүртгэсэн. Үүнээс 14 орчуулагчдын намтар, орчуулгын бүтээлийг цахим мэдээллийн санд оруулж дэмжлэг үзүүлэн ажилласан.	70%
14	1.4.5.. МУХТЖҮЧ 1.1.2, ХАХТЖҮЧ 1.1.1	1.4.5.1.. Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлэх, Монголчуудын уламжлалт төрт ёсоо дээдлэх үзлийг дэлгэрүүлэх зорилгоор түүхт 100 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэх	100 Жилийн ойн бэлтгэл ажлын төлөвлөгөөг гаргаж батлуулсан.	урлаг соёлын үйл ажиллагаа хүргэсэн иргэдийн тоо	Хан Хэнтий Аймгийн түүхт 100 жилийн ойн арга хэмжээг өргөн дэлгэр зохион байгуулж урлаг соёлын үйл ажиллагаа иргэдэд хүргэсэн байна.	Хэнтий аймгийн 100 жилийн ойг 2023 оны 07 дугаар сарын 26,27-ны өдрүүдэд Чингис хотод өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлсэн. 100 жилийн ойг угтаж төв цэнгэлдэх хүрээлэнг шинээр сэргээн засварласан. Баяр наадмын нээлтийн үйл ажиллагааг Хан Хэнтий нутгийн түүх онцлогийг харуулсан "Гүүний үрс гаргах ёслол" зохиомжоор найруулж 500 гаруй уран бүтээлчдийг хамруулан амжилттай зохион байгуулсан. Мөн "Дээлтэй Монгол - 2023" наадам, "Хан Хэнтийн нүүдэлчид" 18 сум тосгодын ардын урлагийн тоглолт болон бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн, "Хаадын хүрээ" буюу МИНИ парк дээр Байт харваа, Тайган нохойн үзүүлбэрүүд тус тус явагдаж наадамчид гадна дотнын жуулчдын анхаарлыг татсан цогц арга хэмжээнүүд болсон. Нээлтийн үйл ажиллагааг давхардсан тоогоор 10000 гаруй үзэгчид гадна дотнын аялагч, наадамчид сонирхсон байна.	100%
15	1.5.1.. МУХТЖҮЧ 3.5, ЗГҮАХ 2.2.1, ХАХТЖҮЧ 3.4.3, АЗДҮАХ-ийн 2.2.3	1.5.1.1.. Монголын Хүүхдийн спортын VII наадамд баг тамирчдаа амжилттай оролцуулах.	Монголын бүх ард түмний спортын 15 дугаар их наадамд түрүүлсэн.	амжилт үзүүлсэн эсэх	Монголын Хүүхдийн спортын VII наадамд амжилт үзүүлсэн байна.	Хүүхдийн спортын VII наадмын өвлийн спортын шигшээ тэмцээнд 64 тамирчин спортын 4 төрөлд оролцож 1 мөнгө, 3 хүрэл медаль хүртэж СДМастер 1 төрсөн. Мөн 2023 оны 6 дугаар сарын 19-29-ний өдрүүдэд Баянхонгор аймагт анх удаа МОНГОЛЫН ХҮҮХДИЙН СПОРТЫН VII НААДМЫН ШИГШЭЭ ТЭМЦЭЭН зохион байгуулагдаж Хэнтий аймгийн 213 тамирчин дасгалжуулагчид спортын 17 төрлөөр амжилттай	100%

					оролцож 6 алт, 6 мөнгө, 15 хүрэл нийт 27 багц медаль хүртэж багийн нийлбэр дүнгээр 7-р байрт шалгарлаа. Баг тамирчдыг оролцуулахад 50.000.000 (тавин сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.		
16		1.5.1.2.. Нийтийн биеийн тамир, спортын хөгжүүлэх чиглэлээр аймгийн хэмжээний нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах	-	арга хэмжээ зохион байгуулсан эсэх, иргэдийн тоо	Спорт, нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хүртээл болгох ажлыг амжилттай зохион байгуулсан байна.	2023 онд БТСГазарт бүртгэлтэй 23 спортын холбоо, 8 клуб, 6 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж биеийн тамирын чиглэлээр "Өглөөний дасгал" хөтөлбөр, "Цаг гаргая", "Цахим алхалт 2023" аяныг тус тус зохион байгуулсан ба биеийн тамирын 85 арга хэмжээнд аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 15110 иргэн хамрагдсан нь өмнөх оноос 5000-аар нэмэгдсэн байна	100%
17		1.5.1.3.. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын анхдугаар наадмыг зохион байгуулах	-	спортын наадам зохион байгуулсан эсэх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын наадмыг амжилттай зохион байгуулсан байна.	Аймгийн Засаг даргын ивээл дор ОУХМ, Алтан гадас одонт Пүрэвцогийн Энхманлайн нэрэмжит Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын анхдугаар наадам 2023оны 09 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулагдаж, нийт 10сум, тосгоны 200 гаруй тамирчид амжилттай оролцсон.	100%

2. 2. ЭДИЙН ЗАСАГ

18	2.1.1.. МУХТЖҮЧ 8.2.2, ЗГҮАХ 3.4.2, ХАХТЖҮЧ 8.2.2, АЗДҮАХ 3.4.3	2.1.1.1.. "Мянганы суут хүн Чингис хаан" цогцолборуудын ажлын үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавих ("Шихихутаг нууц товчоо" түүхэн аялал жуулчлалын цогцолборын барилга, "Их хуралдай" цогцолборын барилга, "Монголын нууц товчоо" цогцолборын барилга)	Цогцолборуудын гүйцэтгэлийн дундаж 70 хувьтай.	гүйцэтгэлийн хувиар	Цогцолборуудын гүйцэтгэлийн дундаж 90 хувьд хүрсэн байна.	Түүхэн аялал жуулчлалын бүс нутгийн хүрээнд баригдаж буй , 6 цогцолборуудын ажлын явц гүйцэтгэл 2022 онд 60 хувьтай байсан бол 2023 онд 93.6 хувьтай үргэлжилж байна.	100%
		2.1.2.1.. "Монгол хатад", "Ёохор наадаан", "Чингис	-			Биндэр суманд "ТОГОРУУНЫ БАЯР-2023" эвент арга хэмжээ Олон Улсын Тогоруу сангийн удирдах зөвлөл, БОАЖЯам, Зэрлэг ан амьтан	100%

19	2.1.2.. МУХТЖҮЧ 3.3.4, ЗГҮАХ 3.4.4, ХАХТЖҮЧ 8.2.1, АЗДҮАХ 3.4.5	фестиваль", "Тогорууны баяр", "Талын түмэн адуу", "Галшар адууны баяр", "Талын тайга нохой" наадам зэрэг эвент арга хэмжээнүүдийн цар хүрээг өргөжүүлэн тогтмол зохион байгуулж, гадаад, дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.		зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	5-аас доошгүй эвент арга хэмжээ зохион байгуулсан байна.	судлах хамгаалах төв болон 2 УТХГазар нутгийн хамгаалалтын захиргаа, Архангай, Дорнод, Хэнтий аймгийн 8 сумын 60 гаруй оролцогчид, Америк, Шинэ-Зеланд, Герман, Швед, Орос, Хятад улсын 22 төлөөлөл жуулчид оролцсоноос гадна дотоодын 2500 орчим иргэн үзэж сонирхсон. "Галшар адууны баяр"-т 4 аймгаас 600 гаруй иргэд оролцлоо. "Талын тайга нохой- 2023" арга хэмжээг Хэрлэн суманд зохион байгуулж 3 аймаг 15 сумын 50 гаруй иргэн 100 гаруй тайга нохойны хамт оролцож, 3 төрлийн тэмцээн зохион байгуулж үзэгчдэд сонирхууллаа. Талын Түмэн Адуу өвөл цагийн эвент арга хэмжээ 11 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулагдаж гадаадын 30 гаруй, дотоодын 3000 гаруй хүн оролцсон. Энэ онд зохион байгуулагдсан 5 эвент арга хэмжээнүүдэд гадаадын 52, дотоодын 7950-н жуулчин, тур оператор 10 гаруй ХХК оролцож үзэж сонирхсон ба өссөн дүнгээр 2023 онд гадаадын 3668, дотоодын 91607 болж, дотоодын жуулчдын тоо 36.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	
20	2.1.3.. МУХТЖҮЧ 3.3.4, ЗГҮАХ 3.4.4, ХАХТЖҮЧ 8.2, АЗДҮАХ 3.4.7	2.1.3.1.. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадваржуулах, үйлчилгээний байгууллагуудын чанар, стандартыг сайжруулах сургалт, зөвлөгөөнийг төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан зохион байгуулна.	Чадавхжуулах сургалтуудад давхардсан тоогоор 200 гаруй хүнийг хамруулж, аймгийн аялал жуулчлалын салбарын зөвлөгөөн зохион байгуулна.	сургалтад хамрагдсан хүний тоогоор	200-аас доошгүй хүн сургалтад хамруулж чадваржуулсан байна.	Хэнтий аймгийн Дадал сумын Баян-Овоо багийн Соёлын төвд "Нутгийн хөгжилд-эмэгтэйчүүдийн оролцоо" сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж аялагчдад ёсзүйн дүрмийг дагаж мөрдүүлэх шаардлага, хэрэгцээ, газартаа жуулчин, амрагч хүлээн авах боломжтой байршуулах хэрэгслийг бий болгох зэрэг 8 чиглэлээр 3 өдрийн турш сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 300 орчим иргэдийг хамруулсан. Мөн Жуулчны баазын эко гэрчилгээжүүлэлт сэдвээр сургалт зохион байгуулж уг сургалтад 50 гаруй хүн хамрагдсан. Нийт 350 иргэдийг аялал жуулчлалын мэдлэг, мэдээлэл, ур чадвар олгох сургалтад хамруулсан.	100%

21	2.2.1.. МУХТЖҮЧ 3.6, АЗДҮАХ 3.5.1	2.2.1.1.. Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах.	-	хөгжлийн төлөвлөгөөтэй болсон сумын тоогоор	Шинээр 4 сум нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй болсон байна.	2023 онд Жаргалтхаан, Биндэр, Баян-Адарга, Норовлин, Баян-Овоо сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг сумдын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, тайланг орон нутагт нь хүлээлгэн өгч, цахим системд байршуулсан. Аймгийн хэмжээнд бүх сумд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй болсон.	100%
22	2.2.2.. МУХТЖҮЧ 6.3.3, АЗДҮАХ 3.5.4	2.2.2.1.. Чингис хотын нөөц усан сан байгуулна	-	ТЭЗҮ хийгдсэн эсэх	Нөөц усан сангийн ТЭЗҮ хийгдсэн байна.	Чингис хотод цэвэр усны эх үүсвэрээс нөөцийн сав байгуулах ажлын гидрогеологийн судалгаа хийгдэж 2024 оны Аймгийн төсөвт 300 сая төгрөгийн зураг төсвийн зардлыг тусгаж ажиллалаа.	50%
23	2.2.3.. МУХТЖҮЧ 4.2.7, ХАХТЖҮЧ 2.4.4, АЗДҮАХ 3.5.5	2.2.3.1.. Үерийн байгууламжийг ашиглалтад оруулна.	Цэнхэрмандал сумын үерийн хамгаалалтын байгууламжийн ажил 70%-тай, Хэрлэн сумын үерийн усны байгууламж 40%-ийн гүйцэтгэлтэй байна.	гүйцэтгэлийн хувиар	Хэрлэн сумын үерийн байгууламжийн ажил дууссан байна.	Хэрлэн сумын Үерийн хамгаалалтын байгууламж 1-р хэсгийн ажил буюу 1009 метр үерийн далан байгууламжийн ажлыг 2021 онд ашиглалтад оруулсан. Тус ажлын үргэлжлэл болох Хэрлэн сумын “Үерийн усны хамгаалалтын далан суваг”-ын ажил 6.2 км ус зайлуулах бетон суваг, аймгийн төвийн авто замын 8,6км ус зайлуулах сувгийн ажлууд бүрэн дууссан.	100%
24	2.2.4.. МУХТЖҮЧ 4.2.12, ХАХТЖҮЧ 8.1, АЗДҮАХ 3.5.7	2.2.4.1.. Дулааны станцын барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	Газар шорооны ажил 80%-ийн гүйцэтгэлтэй байна.	гүйцэтгэлийн хувиар	Барилгын ажил 70%-д хүрсэн байна.	МУ-ын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулагдсан хөнгөлттэй зээлийн гэрээний хүрээнд 10 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар Дулааны станцын барилгын ажлын явц 60 хувьтай үргэлжилж байна.	70%
25	2.2.5.. ХАХТЖҮЧ 8.1, АЗДҮАХ 3.5.10	2.2.5.1.. Бархын голын гүүрийг ашиглалтад оруулах	Батширээт сумын Онон голын төмөр бетон гүүр 95%, Бархын голын төмөр бетон гүүр 5%-ийн гүйцэтгэлтэй байна.	гүйцэтгэлийн хувиар	Бархын голын төмөр бетон гүүрний ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулна.	Бархын голын 121,3 метр урттай төмөрбетон гүүр Улсын төсвийн 4 тэрбум 187 сая төгрөгөөр баригдаж дуусан ашиглалтад орсон.	100%
26	2.3.1.. МУХТЖҮЧ 8.3.1, ЗДҮАХ 3.3.1, ХАХТЖҮЧ 8.3.1, АЗДҮАХ 3.3	2.3.1.1.. Хүнсний хувьсгал хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	-	хэрэгжилтийн хувиар	Хэрэгжилтийг ханган ажиллана.	“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг Хэнтий аймагт хэрэгжүүлэх 17 зорилт 48 арга хэмжээ бүхий төлөвлөгөө батлагдаж 2023 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 90%-тай байна.	90%

27	2.3.2.. МУХТЖҮЧ 8.3.4, ЗГҮАХ 3.3.4, ХАХТЖҮЧ 8.3.4, АЗДҮАХ 3.3.4.	2.3.2.1.. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, оношилгоо шинжилгээний чадавхыг нэмэгдүүлэн малын гаралтай халдварт, гоц халдварт өвчний гаралтыг бууруулах	18 сумын 85 багийн 107 малчин өрхийн 25295 толгой хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад хамруулсан.	Бог малын хээлтүүлэгчийн тоогоор	Бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад хамруулсан байна.	ОНТөсвийн 12.8 сая төгрөгийн хөрөнгөөр Галшар үүлдрийн 2.0 мянган толгой адуу, Галшарын улаан омгийн 5.0 мянган ямаа, Тал нутгийн цагаан үүлдрийн 238 толгой хонь, нийт 7.2 мянган толгой баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийж, 756 толгой малыг ээмэгжүүлж, бүртгэлжүүлсэн. Ангилалтад хамрагдсан нийт малын 33.0 хувийг цөм сүрэгт, 55.7 хувийг үржлийн сүрэгт, 11.3 хувийг хэрэгцээний сүрэгт бүртгэсэн. Цөм сүргийн малын тоог 26.3 хувиар нэмэгдүүлсэн. 4 төрлийн халдварт өвчний өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 595.0 мянган мал хамруулахаас 559.8 мянган мал хамруулж гүйцэтгэл 94.1 хувьтай хийгдсэн. Малаас хүнд халдварладаг галзуу, боом болон бог малын мялзан, хонины цэцэг өвчний нийт 658.9 мян.м2 талбайд голомтыг халдваргүйтгэх ажлыг Мал эмнэлгийн тасаг, үйлчилгээний нэгжүүд хамтран гүйцэтгэсэн халдварт өвчний гаралт өмнөх оноос 40%-иар буурсан.	100%
28	2.3.3.. МУХТЖҮЧ 8.3.4, ЗГҮАХ 3.3.4, ХАХТЖҮЧ 8.3.5, АЗДҮАХ 3.3.4.1.	2.3.3.1.. Мал эмнэлгийн лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулж, үйлчилгээ, оношилгооны чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.	-	тоног төхөөрөмжөөр хангасан эсэх	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна.	Аймгийн Мал эмнэлгийн лабораторид флуоресценцийн микроскоп, ус нэрэгч, хатаах шүүгээ, овоскоп гэх 4 төрлийн багаж, тоног төхөөрөмжийг 41.8 сая төгрөгөөр худалдан авсан. Лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулснаар шинжилгээ цаг хугацаа алдалгүй хийгдэж, малын өвчний оношилгооны баталгаажуулалт 100% үр дүнтэй болсон	100%
29	2.3.4.. МУХТЖҮЧ 8.3.5, ЗГҮАХ 3.3.4, ХАХТЖҮЧ 8.3.5, АЗДҮАХ 3.3.4.3.	2.3.4.1.. Халдварт, гоц халдварт өвчнүүдийн голомтуудыг жил бүр ариутгах ажлыг зохион байгуулна.	-	Халдварт өвчний тоо, хувиар	Халдварт өвчний гаралт өмнөх жилээс буурсан байна.	4 төрлийн халдварт өвчний өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 595.0 мянган мал хамруулахаас 559.8 мянган мал хамруулж гүйцэтгэл 94.1 хувьтай хийгдсэн. Малаас хүнд халдварладаг галзуу, боом болон бог малын мялзан, хонины цэцэг өвчний нийт 658.9 мян.м2 талбайд голомтыг халдваргүйтгэх ажлыг Мал эмнэлгийн тасаг, үйлчилгээний нэгжүүд хамтран гүйцэтгэсэн халдварт өвчний гаралт өмнөх оноос 40%-иар буурсан.	100%

3. 3. ЗАСАГЛАЛ

30	3.1.1.. МУХТЖҮЧ 5.4.1, ЗГҮАХ 4.1.3, ХАЗДҮАХ 4.1.6	3.1.1.1.. Төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангана	Аймгийн нийт хүн амын 70 хувьд мэдээлэл хүрсэн.	мэдээлэл хүргэсэн хүн амын хувиар	Аймгийн нийт хүн амын 75 хувьд мэдээлэл хүрсэн байна.	8 хэвлэл мэдээллийн байгууллага, 1 студитэй гэрээний дагуу хамтран ажиллаж, 1 сайт, 3 пэйж хөтөлж, 10000 орчим мэдээ, мэдээлэл контент бэлдэж, 5000 ширхэг хэвлэмэл материал бэлтгэн иргэдэд хүргэж, ил тод байдлыг хангаж ажилласнаар нийт хүн амын 75 хувьд мэдээлэл хүргэсэн.	100%
31	3.1.2.. МУХТЖҮЧ 5.4.1, ЗГҮАХ 4.1.3, ХАХТЖҮЧ 5.2.1, ХАЗДҮАХ 4.1.7	3.1.2.1.. Иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж төрийн байгууллагын ил тод байдлыг хангах "Иргэдийн оролцоот-Хэтийн Хэнтэй" арга хэмжээг хэрэгжүүлнэ	Иргэдийн оролцоо 80 хувь хүрсэн	Иргэдийн оролцооны хувиар	Иргэдийн оролцоо 85 хувьд хүргэнэ	Иргэдийн оролцоот-Хэтийн Хэнтэй арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласнаар иргэдийн оролцоо 92 хувьд хүрсэн.	100%
32	3.1.3.. МУХТЖҮЧ 5.4.1, ХАЗДҮАХ 4.2.1	3.1.3.1.. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймаг орон нутгийн онцлогт тохируулан жил бүр боловсруулан "Эрх бүхий албан хаагчдын баг"-аар дамжуулан хэрэгжилтийг ханган зохион байгуулна	Улсын дундаж 74.1 хувь. Шударга байдлын үнэлгээгээр 81.1 хувьтай улсын хэмжээнд хоёрт эрэмбэлэгдсэн.	Шударга байдлын үнэлгээний хувиар	Аймгийн Шударга байдлын хувийг үнэлгээ өссөн байна.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг аймагт хэрэгжүүлэх 17 заалттай төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг 100% хангаж ажилласан. Шударга байдлын үнэлгээгээр жил бүр улсын дунджаас тогтмол дээгүүр үнэлэгдэж байна.	90%
33	3.1.4.. МУХТЖҮЧ 5.4.1, ЗГҮАХ 4.2.5.3, ХАХТЖҮЧ 5.2.1, ХАЗДҮАХ 4.2.5	3.1.4.1.. Төрийн албан хаагчдын хэрэгцээ, шаардлагад үндэслэн сургалтын нэгдсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж тухай	Төрийн албан хаагчийн түвшин 65 хувьтай байна.	Түвшин /хувиар/	Төрийн албан хаагчийн түвшин 80 хувьд хүрсэн байна.	"Танхимын болон цахим сургалт"-ын төлөвлөгөөний дагуу сургалтыг жил бүр зохион байгуулж 120 гаруй байгууллагын 11200 гаруй төрийн захиргаа болон үйлчилгээний албан хаагчид хамрагдсан. Төрийн албан хаагчдын түвшин тогтоох шалгалтыг хагас бүтэн жилээр авч дундаж үнэлгээ 74%-тай байна.	90%

		бүр түвшинг тогтооно.					
34	3.2.1.. ХАЗДҮАХ 4.3.6	3.2.1.1.. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 419 дүгээр нээлттэй хорих ангийн цагдан хорих байрыг шилжүүлнэ.	-	гүйцэтгэлийн хувиар	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байрны барилгын ажлыг бүрэн дуусгасан байна.	Барилгын ажилтай холбоотойгоор 2024 оны 2 дугаар сард шилжүүлж өгөхөөр төлөвлөөд байна.	30%
35	3.2.2.. МУХТЖҮЧ 7.4.5, ЗГҮАХ 4.4.8, ХАЗДҮАХ 4.3.8	3.2.2.1.. Мал хулгайлах гэмт хэргийг бууруулна.	Сүүлийн 3-н жилийн дунджаар 178 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.	бүртгэгдсэн гэмт хэргийн тоо/ хувиар	Хулгайн гэмт хэрэг дунджаас 3 хувь буурсан байна.	Аймгийн ГХУСАЗСЗ-өөс "Эзэнтэй мал" арга хэмжээний төлөвлөгөө батлан 100 хувь хэрэгжүүлсний хүрээнд мал хулгайлах гэмт хэрэг өмнөх онтой харьцуулахад 29.0 хувиар буурсан дүнтэй байна.	100%
36	3.2.3.. МУХТЖҮЧ 7.3.5, ЗГҮАХ 4.3.18, ХАЗДҮАХ 4.3.10	3.2.3.1.. "Архидалтгүй хэтийн Хэнтий" арга хэмжээг зохион байгуулна.	10 хувь буюу 5 хүнийг эмийн болон сэтгэлзүйн эмчилгээнд хамруулж, урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг зохион байгуулсан байна.	эмчилгээ болон сургалт сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоогоор	30 хувь буюу 15 хүнийг эмийн болон сэтгэлзүйн эмчилгээнд хамруулж, 266 иргэнд урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг зохион байгуулна.	Архидалтгүй хэтийн Хэнтий арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд "Хэрлэнгийн цэнхэр алс" ТББ, "Өндөрхаан Оршихуй" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллан хорт зуршлаасаа өөрийн хүсэлтээр ангижрах хүсэлт гаргасан 24 хүнийг эмийн эмчилгээнд, 1320 иргэнийг сургалтад хамруулсан байна.	100%
37	3.2.4.. МУХТЖҮЧ 7.3.3, ЗГҮАХ 4.3.11, ХАХТЖҮЧ 7.1.4 АЗДТГ 4.3.11	3.2.4.1.. Сумдад гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын сургууль, удирдах ажилтны сургалт, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр зохион байгуулж гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг шуурхай хүргэнэ.	Хэрлэн суманд 2008 оны Бүсийн аварга шалгаруулах "Гал унтраах техникийн олон төрөлт спортын тэмцээн"-ийг зохион байгуулсан.	арга хэмжээний тоогоор, үр дүнгээр	Онцгой байдлын байгууллагын мэргэжлийн спортын 2023 оны Бүсийн аварга шалгаруулах "Гал унтраах техникийн олон төрөлт спортын тэмцээн"-ийг Бор-Өндөр суманд зохион байгуулсан байна.	Сумдад Иж бүрэн болон Команд штабын дадлага сургуулийг зохион байгуулсан нь сумдын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж сайжруулан, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний зохион байгуулалт, гамшигтай тэмцэх дадлага ур чадвар 85 хувиар дээшилсэн. Сумдын Онцгой комиссын гишүүдэд Ослын үеийн удирдлагын тогтолцоо, Гамшгийн үеийн хариу арга хэмжээний төлөвлөлт, Гамшигтай тэмцэх удирдлагын шийдвэр гаргах чадвар 82 хувиар нэмэгдүүлсэн. Сумдын гамшигтай тэмцэх чадавхи 85.7 хувиар дээшилсэн. 2023 онд Бор-Өндөр суманд зүүн бүсийн Гал унтраах техник спортын олон төрөлт тэмцээнийг зохион байгуулж аймгийн төсвөөс 15 сая төгрөг зарцуулж, Хэнтий аймгийн баг тамирчид тэргүүн байр эзэлсэн.	100%

4. 4. НОГООН ХӨГЖИЛ

38	4.1.1.. ХАХТЖҮЧ 6.4.3, ЗГҮАХ 5.1.9, АЗДҮАХ 5.1.3	4.1.1.1.. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана.	Хог хаягдлын менежмент төлөвлөгөөтэй болсон	сумдын тоо, тоног төхөөрөмжийн хангалтаар	2-оос доошгүй суманд хогны менежментийг хэрэгжүүлж, тоног төхөөрөмж худалдан авна. (шатаагч зуух)	Аймгийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд Чингис хотод 13 ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 93 хувьтай хангаад байна. 17 суманд хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, шатаах зэрэг 36 техник тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн. Дадал суманд АХБанкны санхүүжилтээр хог хаягдлын 2-р зэргийн ландцил төвлөрсөн цэг ашиглалтад орж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаад байна.	100%
39		4.1.1.2.. Дахивар нөөц хүлээн авах, дамжуулах төв байгуулах	Хог хаягдлын менежмент төлөвлөгөөтэй болсон	Гүйцэтгэлийн хувиар	Чингис хотод дахивар нөөц хүлээн авах төв байгуулна.	Хэрлэн сумын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор 2тн/хоног хүчин чадалтай хог хаягдал шатаах зуух худалдан авч, Чингис дагуу дахивар хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах зорилготой цэгийг байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж тохижуулсан. Чингис хот, Бор-Өндөр суманд хуванцар, шил, лааз, гялгар уут, хайлш, цаас зэрэг дахивар хог хаягдлыг ангилан ялгаж преслэн, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлж, хаягдал цаасаар шахмал түлш үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулж, 74.6 тн хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулан хаягдлын хэмжээг 30 хувиар бууруулаад байна.	100%
40	4.1.2.. МУХТЖҮЧ 6.2.5, ЗГҮАХ 5.1.5, ХАХТЖҮЧ 6.2.3, АЗДҮАХ 5.1.4, 5.1.5, "Гучин сая мод" хөтөлбөр, төлөвлөгөө	4.1.2.1.. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажил арга хэмжээг зохион байгуулж, ойжуулалт, ойн зурвас байгуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	Ойжуулалт, ойн зурвас, ногоон байгууламжийн ажлаар 400.0 мянган мод тарьж ургуулсан.	тарьж ургуулсан модны тоогоор	Ойжуулалт, ойн зурвас, ногоон байгууламжийн ажлаар 500.0 мянган мод тарьж ургуулна.	Аймгийн хэмжээнд 545.9 мянган мод тарьж, аймгийн ойн сангийн талбайг 0.04 хувиар, ногоон байгууламжийн талбайг 65 га-аар тус тус нэмэгдүүлж ажиллалаа.	100%
41		4.1.2.2.. Сумын болон сум дундын ойн ангиуд, мод үржүүлгийн газруудад шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлнэ.	Ойн ангиудын мод үржүүлгийн газруудыг өргөжүүлж, талбайн хэмжээг 11.5 га-аар нэмэгдүүлж, хашаажуулсан.	тоног төхөөрөмжийн хангалтаар	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна.	Улсын төсвийн хөрөнгөөр Дадал, Баян-Адарга сумдад нийт 90 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажил, ой бүхий Цэнхэрмандал, Батширээт, Биндэр, Дадал, Норовлин, Дэлгэрхаан сумдад Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал болон ойн мэргэжлийн байгууллагын өөрийн хөрөнгөөр нийт 212 га талбайд ойжуулалтын ажил тус тус	100%

						зохион байгуулж, нийт 302 га талбайд ойг нөхөн сэргээж, ойжууллаа. Мөн мод тарих, үржүүлэх ажлыг техникжүүлэх зорилгоор "Биндэр-ой" сум дундын ойн ангийг улсын төсвийн 205.8 сая төгрөгийн хөрөнгөөр орчин үеийн дэвшилтэд техник тоног төхөөрөмжөөр хангасан.	
42	4.1.3.. МУХТЖҮЧ 6.2.5, ЗГҮАХ 5.1.5, ХАХТЖҮЧ 6.4.3, АЗДҮАХ 5.1.4, 5.1.5, "Гучин сая мод" хөтөлбөр, төлөвлөгөө	4.1.3.1.. Ойжуулалт, ногоон байгууламжийн арчилгаа, цэцэрлэгжүүлэлтийн чиглэлээр сургагч багш нар, хүний нөөцийг бэлтгэж, мод үржүүлгийн газар, жишиг тарьмал ой, архитекторын зөв шийдэл бүхий цэцэрлэгт хүрээлэн зэрэг газраар туршлага судлуулах, дадлагажуулах, чадавхижуулах ажлыг зохион байгуулна.	Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах (STREAM) төслийн санхүүжилтээр 18 хүнийг Улаанбаатар хот, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн мод үржүүлгийн газруудад туршлага судлуулсан.	сургаж, туршлага судлуулсан хүний тоо, үр дүнгээр	100 хүртэл хүнийг сургагч багш, хүний нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр сургаж, туршлага судлуулна.	НҮБ-ын ХХААБ-ын хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуйн менежмент экосистемийн тогтвортой байдлыг хангах төслийн дэмжлэгээр сум дундын ойн ангиудын инженер, техникийн мэргэжилтнүүдийн төлөөлөл 4 хүнийг БНЧУ-д мод боловсруулах үйлдвэрийн технологи, мод үржүүлгийн газруудын үйл ажиллагаа, коллеж, дунд сургууль, их сургуулиудын ойн инженер, техникийн мэргэжилтнүүд бэлтгэх сургуулиудтай танилцаж 14 хоног туршлага судлах сургалтад хамруулж, аймаг орон нутгийн байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод үржүүлэх, тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг судалж, орон нутагтаа нэвтрүүлж суурьшуулахаар ажиллаж байна.	70%
43		4.1.3.2.. Төв суурин газрын ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээг жил бүр нэмэгдүүлж, нийт 65 га-д хүргэнэ.	-	ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээгээр	Ногоон байгууламжийн талбайн хэмжээг 30 га-аар нэмэгдүүлж, арчилгаа хийсэн байна.	Тэрбум үндэсний хөдөлгөөн болон Бүх нийтээр мод тарих арга хэмжээний хүрээнд хот суурингийн ногоон байгууламжид нийт 209.6 мянган ширхэг мод таригдаж, ногоон байгууламж 65 га талбайгаар нэмэгдсэн.	90%

44	4.1.4.. ХАХТЖҮЧ 6.3.1, ЗГҮАХ 5.1.6.1, АЗДҮАХ 5.1.8	4.1.4.1.. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангаж, 80-аас доошгүй булаг, шандны эхийг хашиж хамгаална.	Гурван нуурын усны нөөцийг нэмэгдүүлэх зураг төслийн ажлын судалгаа хийгдэж байна.	хэрэгжилтийн хувь, хашиж хамгаалсан булаг, шандны тоо	Гурван нуурын усны нөөцийг нэмэгдүүлэх зураг төсөв болон Аварга тосон, Бүрд нууруудыг сэргээх ажлыг бүрэн дуусгасан байна.	Бүрд нуурыг сэргээх, ус дөхүүлэх ажлыг "Усны барилга" ХХК батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэж өндөр нь 2.7м, хярын өргөн 3.5м, 139м урттай далан бүхий 13000м.куб ус хуримтлах талбай бүхий далан хийж, 3.9км урттай ус дөхүүлэх сувгийн ажлыг хийж гүйцэтгэн Улсын комисст хүлээлгэж өгсөн. Аварга тосон нуурыг элсний нүүдлээс хамгаалах ойн зурвасыг шинээр байгуулж 10.0 мянган мод тарьсан ба усалгааны асуудлыг гадаргын ус хуримтлуулах хөв цөөрмийн тусламжтай шийдвэрлэж байна. Хэрлэн суманд төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 1тн багтаамжтай 10 ш усалгааны ус нөөцлөх савыг шинээр байгуулсан хамгаалалтын ойн зурвас дагуу байрлуулж усалгаа арчилгааг зохион байгуулж байна.	70%
----	---	--	--	---	--	--	-----

5. 5. АЙМАГ, СУМ ТОСГОДЫН ХӨГЖИЛ

45	5.1.1.. ЗГҮАХ 2.1.12 ЗДҮАХ 2.3.9, ХАХТЖҮЧ 8.1.4, АЗДҮАХ 6.1.6, 6.2.5	5.1.1.1.. Хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу сургууль, цэцэрлэг, дотуур байр, соёлын төв, эрүүл мэндийн барилгуудын ажлуудыг үргэлжлүүлж, шинээр их засвар хийнэ.	УТХО-аар 7 эрүүл мэндийн барилга, 5 соёлын төвийн барилга, 8 цэцэрлэг, цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 5 сургууль, сургуулийн барилгын өргөтгөл, 2 иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга, 5 сургуулийн дотуур байрны барилгын ажил үргэлжилж байна.	ашиглалтад орсон барилгын тоогоор	Шинээр 7-оос доошгүй эмнэлэг, эмнэлгийн өргөтгөлийн барилга, 5-аас доошгүй соёлын төвийн барилга, 8-аас доошгүй цэцэрлэг, цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 5 сургууль, сургуулийн барилгын өргөтгөл, 5-аас доошгүй дотуур байрны барилга, 2-оос доошгүй иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга ашиглалтад оруулна.	2023 онд шинээр 6 эрүүл мэндийн төвийн, 2 Соёлын төвийн барилга, 5 Цэцэрлэгийн барилга, 4 Сургуулийн барилга, 3 Дотуур барын барилга, 1 иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга ашиглалтад орсон байна.	70%
46		5.1.1.2.. Хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу сургууль, цэцэрлэг, дотуур байр, соёлын төв, эрүүл мэндийн	4 сургуулийн барилга, 1 цэцэрлэгийн барилга, 1 дотуур байрны барилга, 1 эмнэлгийн барилга, 2	их засвар хийсэн барилгын тоогоор	4 сургуулийн барилга, 1 цэцэрлэгийн барилга, 1 дотуур байрны барилга, 1 эмнэлгийн барилга, 2 соёлын төвийн барилгад их засвар хийж дуусгаж, шинээр шаардлагатай их засварын ажлыг	2023 онд сумдад 5 конторын барилгын ажил үргэлжилж байгаагаас 1 нь ашиглалтад орж 4 нь он дамжин хэрэгжинэ, 1480 суудалтай 4 сургуулийн барилга ашиглалтад орно, 2 спорт заалны барилга ашиглалтад орно, 1840 суудалтай 5 соёлын барилгаас 1240 суудалтай 3 барилга ашиглалтад орж, 600 суудалтай 2 барилга он дамжин хэрэгжинэ, 700 ортой 5	100%

		барилгуудын ажлуудыг үргэлжлүүлж, шинээр их засвар хийнэ.	соёлын төвийн барилгад их засвар хийж эхлүүлсэн.		эхлүүлсэн байна.	цэцэрлэгийн барилгаас 500 ортой 4 цэцэрлэгийн барилга ашиглалтад орж, 1 барилга он дамжин хэрэгжинэ, 8 эрүүл мэндийн барилгаас 6 барилга ашиглалтад орж, 2 нь он дамжин хэрэгжинэ, 340 ортой 4 дотуур байрын барилгаас 3 нь ашиглалтад орж, 40 ортой 1 барилга он дамжин хэрэгжинэ.	
47		5.1.1.3.. Хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу сургууль, цэцэрлэг, дотуур байр, соёлын төв, эрүүл мэндийн барилгуудын ажлуудыг үргэлжлүүлж, шинээр их засвар хийнэ.	Барилгын ажил 87%-ийн гүйцэтгэлтэй байна.	гүйцэтгэлийн хувиар	Хан-Хэнтий чуулгын барилгыг бүрэн дуусгаж ашиглалтад хүлээлгэж өгсөн байна.	600 хүний суудалтай Хан Хэнтий чуулгын шинэ барилга бүрэн ашиглалтад орж 2023 оны 7-р сарын 26-ны өдөр нээлтээ хийсэн.	100%
48	5.1.2.. МУХТЖҮЧ 4.2.8, ЗГҮАХ 3.5.1, ХАХТЖҮЧ 8.1, АЗДҮАХ 3.5.9	5.1.2.1.. Шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангана.	Жаргалтхаан, Батноров, Хэрлэн сумын 2 дугаар багын шинэ суурьшлийн бүсэд 0,4-ийн агаарын шугам байгуулах ажил хийгдэж эхэлсэн.	агаарын шугам сүлжээ байгуулсан сумын тоогоор	6-аас доошгүй сумын шинэ суурьшлын бүсэд 0.4-ийн агаарын шугам сүлжээ байгуулсан байна.	Улсын төсвийн 650 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дадал, Норовлин, Баянхутаг, Өмнөдэлгэр, Батширээт, Хэрлэн сумдад, ОНХС-ийн 150 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар, Баян-Овоо, Батноров, Хэрлэн сумдад шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангах ажил бүрэн хийж дуусгалаа. Мөн Дадал суманд "Шинэ суурьшлын бүс"-ийн 04 кв-н цахилгаан хангамжийн ажил, Цэнхэрмандал сумын Хужхан багийн төвийн цахилгаан хангамж 35/04 кв-ын АТП, 04 кв-ын ЦДАШ угсрах ажил, Батноров сумын Цахилгаан хангамжийн ажил, Дэлгэрхаан сумын Эгнээ хороололд цахилгааны эх үүсвэр нэмэгдүүлэх ажил бүрэн дуусаж ашиглалтад оруулсан.	100%
49	5.1.3.. МУХТЖҮЧ 4.2.7, ЗГҮАХ 3.6.1 ХАХТЖҮЧ 8.1.1, АЗДҮАХ 6.1.7, 6.2.6	5.1.3.1.. Сумдын төвийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээ болон ариутгах татуургын шугам сүлжээг байгуулна.	1,2 дугаа багийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажил 9%-ийн гүйцэтгэлтэй байна.	гүйцэтгэлийн хувиар	1.2 дугаар багийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлыг үргэлжлүүлнэ.	Хэрлэн сумын гэр хорооллыг хөгжүүлэх чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1, 2 дугаар багийн 2300 өрхийг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг Комфорт Импэкс ХХК, Солармед Монгол ХХК нар 2022 оны 05 сараас эхлэн ариутгах татуургын нийт 15.6 км шугам, дулаан цэвэр усны 13 км шугамын угсралтын ажил гүйцэтгэсэн байна. Гүйцэтгэлийн хувь 95.5%-тай үргэлжилж байна.	90%

50		5.1.3.2.. Сумдын төвийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээ болон ариутгах татуургын шугам сүлжээг байгуулна.	9 сумын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээний ажил 50%-ийн гүйцэтгэлтэй байна.	гүйцэтгэлийн хувиар	Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэлийн дундаж явцыг 70 хувьд хүргэсэн байна.	Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал сум, Батноров сум, Бэрх тосгон/ сумдад цэвэрлэх байгууламж, ус хангамжийн ажил 2022 оноос хойш хэрэгжиж байна. 2023 оны байдлаар Дадал, Баян-Овоо сумдын цэвэрлэх байгууламжийн ажил 90%-тай, Цэнхэрмандал, Баян-Адарга, Норовлин сумдад бохирын шугам сүлжээний ажил, цахилгааны ажил хийгдэж дууссан. Норовлин суманд ус хангамжийн эх үүсвэрийн ажил, цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил хийгдэж байна. Гүйцэтгэл 90%тай үргэлжилж байна. Дэлгэрхаан, Мөрөн, Баянхутаг сумын цэвэр усны эх үүсвэрийн ажил 95%тай үргэлжилж байна.	100%
51	5.1.3.. МУХТЖҮЧ 4.2.7, ЗГҮАХ 3.6.1 ХАХТЖҮЧ 8.1.1, АЗДҮАХ 6.1.7, 6.2.6	5.1.4.. Аялал жуулчлалын маршрутын дагуух сумдыг хатуу хучилттай авто замаар холбоно. (Чингис-Дадал, Норовлин сумаас Баян-Уул, Улаанбаатар-Чингис хот чиглэлийн авто замаас Өмнөдэлгэр сум хүртэлх хатуу хучилттай авто замууд)	Аймгийн хэмжээнд 100 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсон.	ашиглалтад оруулсан авто зам км-ээр	30-аас доошгүй км хатуу хучилттай авто зам ашиглалтад оруулсан байна.	2023 онд Чингис хотоос Бэрх тосгон хүртэл 70 км хатуу хучилттай авто зам, Бэрхээс Батноров сум хүртэл 35 км автозам ашиглалтад орсон. Бэрх тосгоноос Норовлин чиглэлийн 131 км хатуу хучилттай авто замын 75 км далангийн дүүргэлт нягтруулгын ажил үргэлжилж байгаа ба 18 км өнгө болон суурь асфальтбетоны хучилтын ажил, 9 цэгт дугуй хоолойн угсралт, 1 цэгт гүүрний ажил хийгдээд байна ажлын гүйцэтгэл 20 хувь. Мөн Жаргалтхаанаас Өмнөдэлгэр сумыг холбосон 52.5 км хатуу хучилттай авто замын ажил 85 хувьтай байна.	100%
Үнэлгээний дундаж							92.35%